

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ
БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

№ 01/24

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагад шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагын удирдах ажилтны хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар (цаашид "Нийслэлийн Засаг дарга" гэх), нөгөө талаас Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар (цаашид "Удирдах ажилтан", хамтад нь "Талууд" гэх) 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. Талууд Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтооолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтооолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай" 24/33 дугаар тогтоол, энэхүү гэрээний хугацаанд баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтооолыг тус хэрэгжүүлж ажиллана.

1.4. Монгол Улсын Засгийн газраас "2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудтай уялдааг хангаж, шуурхай хамтран ажиллана.

1.5. "Тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хетөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилtot түвшин, хугацаа, хариуцаа нэгжийг тусгана.

Хоёр. Удирдах ажилтны хүлээх үүрэг

2.1. Удирдах ажилтан энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

2.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.2.Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний чиг үүрэгт хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;

2.1.3.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвортой суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албананд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;

2.1.4.байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.5.хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.6. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцэж ажиллах;

2.1.7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.8.дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоомон хугацаанд тайлагнах;

2.1.9.төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэх;

2.1.10.алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;

2.1.11.төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;

2.1.12.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

2.1.13.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялуулах;

2.1.14.хотын хөгжлийн индекс тооцох суурь, анхдагч, мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн Бодлогын

судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;

2.1.15.чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;

2.1.16.чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааний нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;

2.1.17.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугцаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;

2.1.18.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.19.энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.20.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;

2.1.21.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

2.1.22.гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцэж, уялдуулах;

2.1.23.хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцэж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;

2.1.24.Нийслэлийн Засаг даргын “2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай” 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;

Гурав.Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Нийслэлийн Засаг дарга энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

3.1.1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны агентлаг, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргээдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

3.1.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө,

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албыг тогтвортой суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.1.4.харьяа байгууллагуудад төсвийн зорилыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.5.худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангах;

3.1.6.тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох;

3.1.7.төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзах, үйлчилгээ үзүүлэх үргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох;

3.1.8.ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах;

Дөрөв.Гэрээг дүгнэх

4.1.Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 25, бүтэн жилийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.2.Гэрээний хавсралт болох “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний жилийн эцсийн биелэлтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлнэ.

Тав.Гэрээний хариуцлага

5.1.Энэхүү гэрээгээр хүлээсэн үргээ хангалттай биелүүлээгүй, гэрээний хавсралт болох “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлгээлгэнэ.

Зургаа.Бусад зүйл

6.1.Талууд гэрээнд тусгагдсан үргээ харилцан биелүүлнэ.

6.2.Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан бичгээр санал тавьж, зөвшилцэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.3. Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус тус 1 хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ 
Х.НЯМБААТАР

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА 
Д.БАТСҮХ